

ТАНИЛЦУУЛГА

*Газрын тос боловсруулах үйлдвэрийг
дэмжих тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Засгийн газар 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах зорилт дэвшиүүлж, Засгийн газрын 2017 оны 59 дүгээр тогтоолоор Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлзээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадал бүхий “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Үйлдвэрийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг БНЭУ-ын төрийн өмчит “Инженерс Индия Лимитэд” компани боловсруулж, 2018 оны 11 дүгээр сард Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл хэлэлцэж, хүлээн авсан.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн менежментийн зөвлөх (ТМЗ) үйлчилгээний гэрээг 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдөр БНЭУ-ын “Инженерс Индия Лимитэд” компанитай байгуулж, үйлдвэрийн инженерчлэл, зураг төслийн ажлыг эхлүүлсэн.

Өнөөгийн байдлаар үйлдвэрийн инженерчлэл, зураг төсөл боловсруулах ажил амжилттай үргэлжилж, технологийн байгууламжуудын лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байгаа бөгөөд технологийн бус байгууламжийн барилга угсралтын ажил гүйцэтгэх компанитай гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг хангаж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр нь процесийн үндсэн 12 байгууламжтай байх бөгөөд үүнээс 7 нь патенттай технологи юм. Тус байгууламжуудын тендерт Axens, Technip, UOP, Haldor Topsoe, Shell, Kinetics Technology зэрэг нефть-химиийн салбарын дэлхийд тэргүүлэгч компаниуд оролцож байна.

Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын (Инженерчлэл, зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт-ЕРС)-ыг багцуудыг дараах байдлаар хэрэгжүүлэхээр БНЭУ-ын Гадаад хэргийн яам, Экспорт-Импорт банк, Төслийн менежментийн зөвлөх компанийн тохиролцсон. Үүнд:

EPC-I: Технологийн бус барилга байгууламж (Иргэний барилга, ус дамжуулах хоолой, үйлдвэрийн талбайн дэд бүтцийн ажил)

EPC-II: Ахдагч процесийн байгууламжууд болон үйлдвэрийн дэд бүтэц, хангамжийн байгууламж

EPC-III: Үйлдвэрийн цахилгаан станц

EPC-IV: Лицензтэй технологийн байгууламж

Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Экспорт-Импорт банк хооронд 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-т төслийн үндсэн гэрээлэгч, ерөнхий гүйцэтгэгчдийг Энэтхэг улсад бүртгэлтэй компаниудаас сонгохоор заасан учир үйлдвэрийн төлөвлөлт, инженерчлэл, зураг төсөл, гэрээ хэлцэлтэй холбоотой бүхий л баримт бичгүүд олон улсын норм стандартын дагуу англи хэл дээр боловсруулагдаж байна.

Засгийн газрын шийдвэрээр үйлдвэрийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалт болох 27 км салаа төмөр зам, 18,2 км цахилгаан дамжуулах агаарын шугам болон 17,5

км хүнд даацын автозамыг 2018-2019 онуудад барьж байгуулан ашиглалтанд оруулаад байна.

Мөн Дорноговь аймгийн Сайншанд хотод 550 айлын 10 орон сууц, оффис үйлчилгээний цогцолбор бүхий “Газрын тосны үйлдвэрийн хотхон”-ыг байгуулж байгаа бөгөөд, энэ нь нэг талаас үйлдвэрийн барилга угсралтын үед ажиллах гадаад, дотоодын гэрээлэгчдийн ажиллаж, амьдрах нөхцөлийг зах зээлийн үнээс хямд өртгөөр бүрдүүлэх замаар төслийн нийт хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах, нөгөө талаас үйлдвэрийн ажиллагсдыг орон сууцаар хангаж, нийгмийн асуудлыг давхар шийдвэрлэх зорилготой юм.

Монгол улс анх удаа газрын тос боловсруулах чиглэлийн онцгой төвөгшилтэй, иж бүрэн үйлдвэрийг цогцоор нь барьж, нефть-химиин шинэ салбарыг бий болгож байгаа тул барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, батлуулах, норм, дүрэм, стандарт, тээвэр ложистик, гааль гэх мэт олон асуудлыг шийдвэрлэх шаардлага гарч байна.

1. Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн ба дагалдах байгууламжийн бүтээн байгуулалтад олон улсын норм, дүрэм, журам, стандартыг гэрээнд заасан хэлээр хэрэглэх талаар

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Барилгын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, гадаадын барилга байгууламжийн норм, дүрэм, стандартыг бүртгэх, хэрэглэх журам”, “Гадаадын стандарт бүртгүүлэн хэрэглэх журам”-ын дагуу олон улсын стандартыг орчуулан бүртгүүлсний үндсэн дээр Монгол улсад ашиглах боломжтой. Үйлдвэрийн бүтээн байгуулалтын үе шатанд олон улсын **2000 гаруй** норм, дүрэм, стандартыг ашиглахаар байгаа бөгөөд эдгээрийг орчуулж, бүртгүүлэхэд маш их цаг хугацаа, хөрөнгө зардал зарцуулахаар байна. Монгол улс жилдээ ойролцоогоор 10 орчим норм, дүрэм, стандартыг орчуулан нутагшуулдаг байна.

Үйлдвэрийн бүтээн байгуулалтад ашиглагдах **2000 гаруй** олон улсын стандартыг англи хэлээр бүртгэн, нэг удаа ашиглах зөвшөөрөл олгох нь төслийг төлөвлөсөн хугацаанд нь амжилттай хэрэгжүүлэхэд томоохон дэмжлэг болох юм. Харин үйлдвэрийн ашиглалтын үйл ажиллагаанд тогтмол мөрдөх норм, дүрэм, журам, стандартыг боловсруулж, батлуулахаар суурь судалгааг хийж байна.

2. Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн ба дагалдах байгууламжийн зураг төслийг боловсруулах, баталгаажуулах, зураг төсөлд магадлал хийх, барилгын ажилд хяналт тавих, ашиглалтанд хүлээн авах талаар

Гадаадын компаниудын боловсруулсан онцгой төвөгшилтэй цогцолбор үйлдвэрийн зураг төслийг Монгол улсын Барилгын тухай хууль, холбогдох дүрэм, журмын дагуу монгол хэл дээр орчуулан, улсын экспертизээр магадлал хийлгэх нь газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын хугацааг маш ихээр хойшлуулахаар байна. Тиймээс, зураг төслийг гүйцэтгэгч гадаадын компанийтай байгуулсан гэрээний хэл буюу англи хэлээр хүлээн авах, магадлал хийх, түүний дагуу хяналт тавих эрхзүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Нефть-химиин салбарын барилга байгууламжийн төвөгшил ихтэй, олон үе шаттай зураг төслийг баталгаажуулах, зураг төсөлд магадлал хийх, барилгын ажлын зөвшөөрөл авах, хяналт тавих, ашиглалтанд хүлээн авах зэрэг ажлыг

хялбаршуулсан горимоор зохицуулах нь төслийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой байна.

3. Төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаар

Монгол улсад анх удаа газрын тос боловсруулах онцгой төвөгшилтэй, иж бүрэн үйлдвэр барьж байгуулж байгаа тул олон тооны гадаадын инженер, техникийн ажилтнууд үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцох бөгөөд урьдчилсан тооцоогоор барилга угсралтын ажлын үед буюу 2021 онд 1000, 2022 онд 5000, 2023 онд 8000, 2024 онд 7000 орчим (давхардсан тооогоор) инженер, техникийн болон туслах ажилчид ажиллахаар байна.

Иймд, ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авах, Монгол улсад хөдөлмөр эрхлэхтэй холбогдсон зөвшөөрлийг шуурхай олгох асуудлыг хуулийн төслийн 3.3-д заасан журмаар зохицуулахаар хуулийн төсөлд тусгалаа.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 21/14 дүгээр Зөвлөмж, Засгийн газрын 2019 оны 284 дүгээр тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд ахуйн хэрэгцээнд шаардлагатай усыг Бор Хөөвөрийн.govийн газрын доорх усны ордоос хангахаар шийдвэрлэсэн. Засгийн газрын 2014 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр судалж тогтоосон газрын доорх усны нөөцийн эрэл, хайгуул, судалгааны зардлыг ус ашиглагчаар эргүүлэн төлүүлэх журам"-ын дагуу усны ордын нөхөн төлбөр болох 2 тэрбум орчим төгрөгийг төлөхөөр байна.

"Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр зөвхөн үйлдвэрийн үндсэн бүтээн байгуулалтын ажил, харин үйлдвэрийн гаднах дэд бүтэц, "Газрын тосны үйлдвэрийн хотхон"-ы бүтээн байгуулалтын ажлууд, төсөл хэрэгжүүлэгч компанийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны өндөр хүүтэй (жилийн 12 хувь) зээлээр санхүүжиж байгаа тул усны ордын нөхөн төлбөрөөс чөлөөлөх шаардлагатай байна. Улсын орлого болох дээрх нөхөн төлбөрийг Хөгжлийн банкны өндөр хүүтэй зээлээр төлөх нь үргүй зардлаас гадна, төслийн нийт өртөг зардлыг өсгөж, улмаар үйлдвэрлэлийн ашигт сөргөөр нөлөөлж, улсад хохиролтой юм.

Зээлийн ерөнхий хэлэлцээрийн дагуу үйлдвэрийн бүтээн байгуулалтанд ашиглагдах машин механизм, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, түүхий эд, бараа материалын худалдан авалтын 65 хувийг БНЭУ-аас хангах ба зарим технологийн байгууламжийн тоног төхөөрөмж нь хэт том овортой, 100 тн орчим байх тул тээвэрлэлтийг шуурхай явуулах тусгайлсан журам, эдгээр олон төрлийн их хэмжээний тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бараа материалын гаалийн бүрдүүлэлтийг цаг хугацаа алдалгүй хийх, шат дамжлагыг багасгах эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Иймээс газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолой, тэдгээрийн үндсэн ба дагалдах байгууламжийн барилга угсралтанд шаардлагатай машин механизм, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, түүхий эд, бараа материалын тээвэрлэлтийг хөнгөвчлөх, гаалийн бүрдүүлэлтийг хялбаршуулсан/түргэвчилсэн горимоор зохицуулах шаардлагатай байна.

4. Түүхий эдийн хангамжийн талаар

Өөрийн орны түүхий эдийн нөөцөд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулж буй манай улсын хувьд тус үйлдвэрийг түүхий тосоор тасралтгүй, найдвартай хангах нь асуудал тулгамдаж байна. Газрын тос боловсруулах

үйлдвэрийн хүчин чадлыг 2012 онд Газрын тосны газар (хуучин нэрээр)-ын Хайгуул, ашиглалтын техникийн зөвлөлөөр хэлэлцүүлж, тус газрын даргын 125 дугаар тушаалаар батлуулсан "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн "Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсан түүхий тосны олборлолтын төлөвлөгөөнд суурилан 1.5 сая тонн байхаар тогтсон.

Гэтэл газрын тосны Тосон-Уул, Тамсагийн ордуудад үйл ажиллагаа явуулж буй "Петрочайна Дачин Тамсаг" ХХК нь сүүлийн жилүүдэд тодорхой шалтгаануудын улмаас, тухайлбал, бүс нутгийн эрчим хүчний хангамжийн дутагдал, орон нутгийн эсэргүүцэл, дэлхийн зах зээл дээрх түүхий тосны үнийн уналт зэргээс хамаарч олборлолтыг төлөвлөсөн хэмжээнд хүргэхгүй байгаа төдийгүй, цаашид ч бууруулахаар төлөвлөж байгаа нь стратегийн чухал ач холбогдол бүхий газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр тасралтгүй, найдвартай хангаж чадахгүйд хүрэх, түүнчлэн олборлогч компаниудын хараат байдалд орох эрсдэл үүсч болзошгүй байна.

Иймд, төрийн өмчит газрын тос боловсруулах үйлдвэр түүхий эдийн хангамжийн хувьд тогтвортой, найдвартай эх үүсвэртэй байх үүднээс өөрийн гэсэн түшиц газар буюу газрын тосны ордтой болох эрхзүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай байна.

Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд тулгамдаж буй дээр дурдсан асуудлуудыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих бие даасан хуулийн төсөл боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулахыг Засгийн газарт даалгасан.

Энэхүү хууль батлагдсанаар газрын тос боловсруулах үйлдвэр төлөвлөсөн хугацаандаа ашиглалтанд орж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, хөрөнгө оруулалтын зардлыг богино хугацаанд нөхөж, зээлийн санхүүжилтийн эргэн төлөлтийг хугацаанд нь хийх боломж бүрдэх юм.

Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн ерөнхий бүтэц нь долоон зүйлтэй бөгөөд хуульд заасан харилцааг "Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих, төрөөс үзүүлэх үйлчилгээг хялбаршуулсан горим"-ын тухай журмаар нарийвчлан зохицуулна.

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2020.12.17